



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 492

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд
төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх
гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 05/9982 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан "Архангай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компани, "Өвөрхангай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компани, "Хархорин АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Ж.Баттулга /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн/, Э.Лувсандагва /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн/ нарыг томилсугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД

0000991